I N F O R M A C E   P R O   C I Z I N C E

# ŽÁDOST O TRVALÝ POBYT

## NA ÚZEMÍ ČESKÉ REPUBLIKY

## A POVINNOST CIZINCE PROKÁZAT ZNALOST ČESKÉHO JAZYKA

ČEŠTINA pro cizince

### *Povinnost cizince prokázat znalost českého jazyka*

Podle platného zákona o pobytu cizinců na území České republiky (č. 326/1999 Sb.) je cizinec od 1. ledna 2009 povinen k žádosti o povolení k trvalému pobytu předložit i osvědčení o vykonání zkoušky z českého jazyka na úrovni A 1.

Cizinec by se proto měl ještě před podáním žádosti o povolení k trvalému pobytu přihlásit ke zkoušce z českého jazyka.

### *Poukaz k vykonání zkoušky z českého jazyka*

Cizinec má nárok na jednu zkoušku z českého jazyka na této úrovni zdarma, a to po předložení tzv. poukazu.

O poukaz může cizinec osobně a bezplatně požádat od 1. září 2008 na pracovištích odboru azylové a migrační politiky Ministerstva vnitra. Poukaz bude cizinci vydán jen jednou a platí pouze pro osobu, která bude v poukazu uvedena.

### *Zkouška z českého jazyka a osvědčení o vykonání zkoušky*

Cizinec se může přihlásit ke zkoušce z českého jazyka pouze na některé ze škol, které jsou uvedeny v tzv. seznamu škol. Po úspěšném vykonání zkoušky obdrží osvědčení.

### *Další informace*

Podrobné informace ke zkoušce z českého jazyka, k přípravě na zkoušku, k seznamu škol, k vydávání poukazů a osvědčení o vykonání zkoušky a další informace jsou uvedeny na webových stránkách Ministerstva školství, mládeže a tělovýchovy:
**www.cestina-pro-cizince.cz, www.check-your-czech.com**

***Bližší informace je možné rovněž získat***
***na bezplatné informační telefonní lince: 800 400 469***

*Leták byl vydán ve spolupráci Výzkumného ústavu pedagogického v Praze, Ministerstva školství, mládeže a tělovýchovy a Ministerstva vnitra. Srpen 2008*

Г А Д А А Д   И Р Г Э Д Э Д   М Э Д Э Э Л Э Л

# БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛСАД БАЙНГА ОРШИН СУУХ ӨРГӨДӨЛ БА ЧЕХ ХЭЛНИЙ МЭДЛЭГ ШАЛГУУЛАХ ГАДААД ИРГЭДИЙН ҮҮРЭГ

ГАДААД ИРГЭДЭД
зориулсан чех хэл

## Чех хэлний мэдлэг шалгуулах гадаад иргэдийн үүрэг

Бүгд Найрамдах Чех улсын нутаг дэвсгэр дээр гадаад иргэд оршин суух тухай хүчин төгөлдөр хуулийн дагуу (1999 оны 326-р хуулийн эмхтгэл) гадаад иргэн 2009 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн байнга оршин суух зөвшөөрөл хүсэх өргөдөлд чех хэлний A1 төвшний шалгалт өгсөн тухай гэрчилгээг хавсаргах үүрэгтэй.

Ийм учраас гадаад иргэн байнга оршин суух зөвшөөрөл хүсэх өргөдөл гаргахаасаа өмнө чех хэлний шалгалтанд бүртгүүлсэн байх ёстой.

## Чех хэлний шалгалт өгөх эрхийн бичиг

Гадаад иргэн чех хэлний A1 төвшний нэг шалгалтыг эрхийн бичгээр үнэгүй өгч болно.

Эрхийн бичгийг 2008 оны 9-р сарын 1-ээс эхлэн Дотоод яамны Орогнох эрх болон шилжин суурьших хөдөлгөөний бодлогын тасгийн ажлын байруудад өөрийн биеэр үнэгүй шаардаж болно. Эрхийн бичиг гадаад иргэнд нэг л удаа олгогдох ба зөвхөн эрхийн бичиг дээр нэр нь бичигдсэн хүнд үйлчилнэ.

## Чех хэлний шалгалт ба шалгалт өгсөн тухай гэрчилгээ

Гадаад иргэн чех хэлний шалгалт өгөхдөө зөвхөн бүртгэлд орсон сургуулиудын аль нэгэнд бүртгүүлж болно. Шалгалт амжилттай өгсний дараа гэрчилгээ гардан авна.

## Бусад мэдээлэл

Чех хэлний шалгалт, шалгалтын бэлтгэл, сургуулиудын жагсаалт, эрхийн бичиг олголт, шалгалт өгсөн тухай гэрчилгээ болон бусад асуудлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Боловсрол, залуучууд ба биеийн тамирын яамны **www.cestina-pro-cizince.cz** вэб хуудаснаас харна уу.

***Асууж лавлах зүйл гарвал 800 400 469 утсаар үнэ төлбөргүй ярьж болно.***

*Сурталчилгааны материалыг Прага хот дахь сурган хүмүүжүүлэх эрдэм шинжилгээний хүрээлэн, Боловсрол, залуучууд ба биеийн тамирын яам болон Дотоод яамтай хамтран гаргав. 2008 оны 8-р сар*